



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 626

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 42,300,000.00 (дөчин хоёр сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Билгүүн, Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

000110

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2019 оны 12 дугаар сарын 26ны өдрийн  
 66. дугаар тогтоолын хавсралт

**УВС АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРЛЭЛГЭЙ,  
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ**

Д/д	Хөрөнгийн нэр, дугаар	Үйлд-сэн/ Ашиглалтад орсон он	Гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин, Тойото Ланд круизер-100, улсын дугаар УВХ 70-08, JТ111ТJA008012581	1999/2011	245,240.00	42,300,000.00	42,300,000.00	0.00	4,500,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>42,300,000.00</b>	<b>42,300,000.00</b>	-	<b>4,500,000.00</b> (дөрвөн сая таван зуун мянга)